**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ**

2024 оны 09 сарын 13 өдөр Дугаар 418 Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 11 нэр төрлийн 61,799,800.00 (жаран нэгэн сая долоон зуун ерэн есөн мянга найман зуу) төгрөгийн балансын үнэ, 6,050,681.22 (зургаан сая тавин мянга зургаан зуун наян нэг төгрөг хорин хоёр мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг Жижиг дунд, үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, “Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал Д.Зоригт, Жижиг дунд, үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд”-д бүртгэх;

2.3.Тээврийн хэрэгслийг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ, АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ

132001942

20-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны ..09... дугаар сарын ..13...-ны өдрийн
..1/8... дугаар тогтоолын хавсралт

"ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГЫН ХУРДАСГУУР ТӨВ" УТҮГ-ЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨНД БҮРТГЭЛТЭЙ, ЖИЖИГ ДУНД, ҮЙЛДВЭРИЙН ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| Д/д | Хөрөнгийн нэр | Ашиглалтад орсон огноо | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Балансын үнэ | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэгдэл өртөг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | (төгрөг) | | | |
| | Компьютер, дагалдах хэрэгсэл | | | | | | | |
| 1 | Dell Latitude 5440 /Зөөврийн компьютер/ | 2024.06.11 | ш | 5 | 3,491,910 | 17,459,550.00 | 1,913,376.00 | 15,546,174.00 |
| 2 | Dell Latitude 5440 /Зөөврийн компьютер/ | 2024.06.11 | ш | 5 | 3,491,910 | 17,459,550.00 | 1,913,376.00 | 15,546,174.00 |
| 3 | Dell Latitude 5440 /Зөөврийн компьютер/ | 2024.06.11 | ш | 2 | 3,491,910 | 6,983,820.00 | 765,350.40 | 6,218,469.60 |
| 4 | Принтер HP 135A Laser | 2024.05.28 | ш | 2 | 544,900 | 1,089,800.00 | 140,330.72 | 949,469.28 |
| 5 | Dell 22 Дэлгэц /21.5 инч/ | 2024.06.11 | ш | 5 | 450,708 | 2,253,540.00 | 246,964.00 | 2,006,576.00 |
| 6 | Dell 22 Дэлгэц /21.5 инч/ | 2024.06.11 | ш | 5 | 450,708 | 2,253,540.00 | 246,964.00 | 2,006,576.00 |
| 7 | Star Link-ийн төхөөрөмж | 2024.06.05 | ш | 1 | 1,677,500 | 1,677,500.00 | 197,623.70 | 1,479,876.30 |
| | Компьютер, дагалдах хэрэгслийн дүн | | | 25 | | 49,177,300.00 | 5,423,984.82 | 43,753,315.18 |
| | Тавилга, эд хогшил | | | | | | | |
| 8 | 4 ажилтны ширээ | 2024.05.22 | ш | 3 | 2,232,500 | 6,697,500.00 | 366,786.00 | 6,330,714.00 |
| 9 | Бичгийн шүүгээ /Шилэн хаалгатай/ | 2024.05.22 | ш | 3 | 455,000 | 1,365,000.00 | 74,754.00 | 1,290,246.00 |
| 10 | Бичгийн шүүгээ /Шилэн хаалгагүй/ | 2024.05.22 | ш | 3 | 420,000 | 1,260,000.00 | 46,002.00 | 1,213,998.00 |
| 11 | Хар сандал /Хүзүү амраагчтай/ | 2024.06.14 | ш | 12 | 275,000 | 3,300,000.00 | 139,154.40 | 3,160,845.60 |
| | Тавилга, эд хогшлын дүн | | | 21 | | 12,622,500.00 | 626,696.40 | 11,995,803.60 |
| | Нийт дүн | | | 46 | | 61,799,800.00 (Жаран нэгэн сая долоон зуун ерэн есөн сая найман зуу) | 6,050,681.22 (Зургаан сая тавин мянга зургаан зуун наян нэгэн төгрөг хорин хоёр мөнгө) | 55,749,118.78 (Тавин таван сая долоон зуун дөчин есөн мянга нэг зуун арван найман төгрөг далан найман мөнгө) |